

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЭ ЭРИН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.АМАРТҮВШИН
ТАНАА

2020.02.21 № 06/573
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэ эрин сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шинэ эрин сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинэ эрин сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шинэ эрин сургуулийн захирал Б.Амартүвшин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн орлогын болон зардлын данстай холбоотой, санхүүгийн тайлангийн бүрдлийг хангах, сургуулийн барилгын газрын асуудлыг шийдвэрлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэ эрин сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 5-ноос 2020 оны 2 дугаар сарын 13-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, гэрээт ажилтан М.Ганбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 02/01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шинэ эрин сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйл бүхий хүмүүнлэг Монгол иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 179 дүгээр тогтоолоор Шинэ эрин сургуулийг байгуулж, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Монгол Улсын бүрэн дунд боловсролын томоохон шинэчлэл болох Олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн Кембрижийн их сургуулийн дэргэдэх Олон улсын Үнэлгээний төвийн гаргадаг сургалтын хөтөлбөр, үнэлгээний нэгдмэл үйлчилгээг Монгол Улс боловсролын тогтолцоондоо нэвтрүүлж, харилцан судалж, хос хэлний хөтөлбөртэй сургуулийг байгуулж, сурагч, багш, сургуулийн оролцдог үнэлгээ, түүний батламж нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, сурагч ирээдүйд эзэмших мэргэжил сонирхолдоо тулгуурлан хичээлээ, хөтөлбөрөө, шалгалтын даалгавраа сонгодог уян хатан сонголт, сургуулийн хөгжил, удирдлага зохион байгуулалт нь шинэлэг бөгөөд судалгаанд тулгуурласан шийдвэртэй гэдгээрээ онцлог юм.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Шинэ эрин сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шинэ эрин сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ийн “Аcolous” төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн систем программ хангамж ашигладаг байна.

Шинэ эрин сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Шинэ эрин сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээрх нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,176,498.2 мянган төгрөгөөс тооцон 23,530.0 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 23,337.2 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,166,860.5 мянган төгрөгөөс тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шинэ эрин сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 130,767.0 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, өр төлбөр, Засгийн газрын оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	279.6	0	-279.6
Бараа материал	116,553.6	70,434.5	-46,119.1
Үндсэн хөрөнгө	4,825,921.8	4,591,106.1	-234,815.7
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-810,406.7	-659,959.3	150,447.4
Нийт хөрөнгө	4,132,348.3	4,001,581.3	-130,767.0
Өр төлбөр	1,126.0	2,218.7	1,092.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,131,222.3	3,999,362.6	-131,859.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,132,348.3	4,001,581.3	-130,767.0

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн өөрчлөлт нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 279.6 мянган төгрөгөөр буурсан нь НДШ-ийн илүү төлснөөс үүссэн авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46,119.1 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал 17,647.4, аж ахуйн материал 14,173.2, бусад хангамжийн материал 7,191.8, нийт 39,012.4 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Мөн аж ахуйн материал 5,741.8, сэлбэг хэрэгсэл 1,535.1, бусад хангамжийн материал 800.4, бичиг хэргийн материал 363.0, түлш, шатах тослох материал 141.0, нийт 8,581.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь өмнөх оны үлдэгдлийг бууруулсан байна.

Тайлан оны эцэст сэлбэг хэрэгсэл, түлш, шатах тослох материал данс үлдэгдэлгүй болжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 84,368.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл 234,815.7 мянган төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн 150,447.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд тавилга эд хогшил 24,048.5, машин, тоног төхөөрөмж 13,828.0, нийт 37,877.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал данснаас шилжүүлэн авч, 9,558.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 447 дугаар тогтоолоор 50,654.2 мянга, А-1/3719 тоот албан бичгээр 231,597.5 мянга, нийт 282,251.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах зөвшөөрлийн дагуу машин тоног төхөөрөмж 251,375.3 мянга, тавилга, эд хогшил 21,580.5 мянга, ном 9,295.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,092.7 мянган төгрөгөөр өссөн нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д төлөх 1,946.2 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний, Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст төлөх 272.4 мянган төгрөгийн шимтгэлийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,999,362.6 мянган төгрөг болж, 131,859.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,003,735.4 мянган төгрөгийг урсгал зардлын төсөв батлагджээ.

Нийт зардлын 999,735.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлыг 1,003,735.4 мянган төгрөгөөр төлөвлөснөөс, 1,003,202.2 мянган төгрөгийн гүйцэтгэл тайлагнаж, 533.2 мянган төгрөг дутуу зарцуулагдсан байна. Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнгээр болон зардлын зүйл ангиар хянагдах зардлууд хэмнэгдсэн байна. Зарцуулагдаагүй 533.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,003,202.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 446.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 63.1 мянга, урсгал засвар 14.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 5.4 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардал 3.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэнэс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 31,325.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 30,875.5 мянган төгрөгийг зарцуулж, 450.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,628,736.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,592,570.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,764.4 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 31,401.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Захирлын 2019 оны 2 дугаар сарын 15 өдрийн А/05 тушаалаар багш, ажилчдын 2018 оны 9-12 сар, 2019 оны 1 дүгээр сарын ажлын үр дүнгээр 2019 оны 2-6 сарын ур чадварын нэмэгдлийг, 2019 оны 6 дугаар сарын 14 өдрийн А/13 тушаалаар багш нарын 2-6 сарын ажлын үр дүнгээр 2019 оны 9-12 сарын ур чадварын нэмэгдлийг олгохдоо 3,225.9 мянган төгрөг илүү олгожээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдэл 3,225.9 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон,

2. Захирлын 2019 оны 2 дугаар сарын 15 өдрийн А/06 тушаалаар багш, ажилчдын 2018 оны 9-12 сар, 2019 оны 1 дүгээр сарын ажлын үр дүнгээр 2019 оны 1.2 дугаар улирлын урамшуулал,

2019 оны 6 дугаар сарын 14 өдрийн А/14 тушаалаар багш нарын 2-6 сарын ажлын үр дүнгээр 3, 4 улирлын урамшуулал олгохдоо 1,438.5 мянган төгрөгийн урамшуулал илүү олгожээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшуулал 1,438.5 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон,

3. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 447 дугаар тогтоолоор 50,654.2 мянга, А-1/3719 тоот албан бичгээр 231,597.5 мянга, нийт 282,251.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах зөвшөөрлийн дагуу машин тоног төхөөрөмж 244,301.5 мянга, тавилга, эд хогшил 21,580.5 мянга, ном 9,295.7 мянга, нийт 275,177.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж 7.074.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдаагүй үлдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлээгүй, оршин байх, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдсэн

4. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх болон 2019 оны 01 дүгээр сарын 01-нээрх үлдэгдлийг 1,585,496.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлээгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдсэн

Аудитаар илэрсэн 31,401.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн авч үзэх буюу анхаарал татахуйц асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шинэ эрин сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 75 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 10 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмж өгөгдсөний 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, үлдэгдэл өртөг тэг болсон County маркийн автобусыг дахин үнэлээгүй, 2019 оны тооллогыг дутуу нэгтгэсэн, үр дүнг хэлэлцээгүйгээс 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинэ эрин сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулалгүйгээр 30,875.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын Мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-аас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Орлогын төлөвлөгөө тасрах, журам, зааврыг хэрэгжүүлэн ажиллаагүй байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлуулж, төвлөрүүлж ажиллах;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

2. Сургуулийн газрын асуудал

2.1. Илрүүлэлт:

Ерөнхий боловсролын 640 хүүхдийн сургуулийн/эскиз/ 2008 оны зургаар 1,369.2 кв.м /45.64x30/ талбай бүхий 3 давхар сургуулийн барилга, 125 кв.м /25x 5/ талбай бүхий автомашины гарааш Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 20 дугаар сургуулийн хашаанд

баригдсан байна. Сургуулийн барилга, автомашины гараашийн талаарх мэдээлэл, холбогдох бичиг баримт материал хангалтгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2-т "барилга байгууламж барих, өргөтгөхөд зориулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай асуудлыг газрын тухай хууль тогтоомж, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн шийдвэрлэх", Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу гаргана", Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т "Барилга байгууламж барих эрхийн үндсэн дээр баригдсан барилга байгууламж өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд энэ хуулийн 10 дугаар зүйлд заасныг баримтална" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

2.2. Эрсдэл:

Сургууль өөрийн эзэмшлийн газаргүй байх нь гаднах талбайн тохижилт, өргөтгөл хийх боломж хязгаарлагдах, гэнэтийн осол аваарын үед нүүлгэн шилжүүлэлт хийх гарц, орц тодорхой биш байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Барилгын тухай хууль, Газрын тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, сургууль эзэмшлийн газрын асуудлыг шийдвэрлүүлэх;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс санхүүгийн үр дүнгийн тайлан 302.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Цалингаас НДШ 144.6, ХХОАТ 79.1 сая төгрөгөөр тус тус илүү суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангууд буруу илэрхийлэгдэх;

3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу санхүүгийн тайлангуудыг үнэн зөв гаргаж тайлагнах;

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тус сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Үндэсний аудитын газарт ирүүлэхдээ тайлбар тодруулга дутуу ирүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

5.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн бүрдэл хангагдахгүй, онцлог үйл ажиллагааны мэдээллийн талаарх ойлголтгүй байх;

5.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг бүрэн гаргаж, хэрэглэгчийг мэдээллээр ханган ажиллах;

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	116,833,239.76	70,434,572.83
33	АВЛАГА	279,686.86	0.00
335	Бусад авлага	279,686.86	0.00
3351	Байгууллагаас авах авлага	279,686.86	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	116,553,552.90	70,434,572.83
351	Түүхий эд материал	62,353,417.50	45,045,591.83
35110	Тусгай зориулалттай материал	62,353,417.50	45,045,591.83
354	Хангамжийн материал	54,200,135.40	25,388,981.00
35410	Бичиг хэргийн материал	2,890,196.00	2,527,238.00
35420	Аж ахуйн материал	37,905,093.00	17,990,149.00
35430	Сэлбэг хэрэгсэл	400,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	141,044.40	00.00
35470	Бусад хангамжийн материал	12,863,802.00	4,871,594.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,015,515,089.08	3,931,146,708.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,015,515,089.08	3,931,146,708.16
392	Биет хөрөнгө	4,011,946,652.97	3,928,493,457.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,750,560,295.00	3,750,560,295.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-66,974,291.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,800,000.00	60,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-60,800,000.00	-60,800,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	411,155,611.87	173,901,950.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-374,172,495.42	-140,207,112.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	469,421,581.06	481,125,408.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-330,235,260.49	-345,700,204.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,744,680.00	4,744,680.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-163,609.68
39217	Ном	80,472,240.95	71,206,340.95
393	Биет бус хөрөнгө	3,568,436.11	2,653,250.35
39301	Програм хангамж	48,767,381.74	48,767,381.74
39302	Хуримтлагдсан элэгдэл	-45,198,945.63	-46,114,131.39
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,132,348,328.84	4,001,581,280.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,126,009.00	2,218,637.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,126,009.00	2,218,637.76
413	Өглөг	1,126,009.00	2,218,637.76
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	272,436.49
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,126,009.00	1,946,201.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,131,222,319.84	3,999,362,643.23
51	Засгийн газрын хувь оролцоо	4,131,222,319.84	3,999,362,643.23
511	Засгийн газрын оруулсан капитал	3,132,187,517.32	3,132,187,517.32
51101	Өмч: - төрийн	3,132,187,517.32	3,132,187,517.32
512	Хуримтлагдсан үр дүн	-885,365,006.97	-1,017,224,683.58
51210	Өмнөх үеийн үр дүн	-885,365,006.97	-885,365,006.97
51220	Тайлант үеийн үр дүн		-131,859,676.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,884,399,809.49	1,884,399,809.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,132,348,328.84	4,001,581,280.99

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	940,628,560.00	1,082,174,074.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,160.00	47,113,174.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,160.00	37,877,306.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,160.00	37,877,306.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,160.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	37,877,306.00
122	Тусламжийн орлого	00.00	9,235,868.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	9,235,868.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	940,620,400.00	1,035,060,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	895,514,900.00	1,003,735,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	895,514,900.00	1,003,735,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,105,500.00	31,325,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,055,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,050,000.00	31,325,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,116,537,070.37	1,166,860,544.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,116,537,070.37	1,166,860,544.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,111,646,952.53	1,156,992,363.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	717,709,944.18	794,022,451.19
210101	Үндсэн цалин	716,209,944.18	794,022,451.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,500,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,975,775.05	99,641,835.95
210201	Тэтгэврийн даатгал	84,975,775.05	67,749,826.30
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	8,674,809.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	6,348,630.86
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,534,216.78
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	15,334,352.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,564,908.93	47,758,092.27
210301	Гэрэл, цахилгаан	24,461,526.29	25,619,742.99
210302	Түлш, халаалт	17,713,682.64	17,343,926.32
210303	Цэвэр, бохир ус	3,389,700.00	4,794,422.96
2104	Хангамж, бараа материалын зардал	21,814,402.14	27,714,604.42
210401	Бичиг хэрэг	6,639,656.00	3,743,878.00
210402	Тээвэр, шатахуун	4,675,829.40	2,949,894.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,102,490.74	7,629,099.04
210404	Ном, хэвлэл	186,900.00	256,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,209,526.00	12,535,732.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,252,730.00	7,747,485.00
210604	Урсгал засвар	6,252,730.00	7,747,485.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,848,558.00	39,641,044.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,284,408.00	34,360,395.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00

Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,400.00	127,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,500.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,406,250.00	3,123,249.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	214,480,634.23	140,466,850.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,753,351.73	17,958,395.61
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	190,727,282.50	122,508,454.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,890,117.84	9,868,181.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	8,885,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,885,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,890,117.84	983,181.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,890,117.84	983,181.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-175,908,510.37	-84,686,470.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	535,320.16	47,173,206.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	9,295,900.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	37,877,306.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	535,320.16	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-535,320.16	-47,173,206.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-176,443,830.53	-131,859,676.61

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	941,299,192.09	1,035,060,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	678,792.09	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	678,792.09	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	678,792.09	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	940,620,400.00	1,035,060,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	895,514,900.00	1,003,735,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	895,514,900.00	1,003,735,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,105,500.00	31,325,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,055,500.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,050,000.00	31,325,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	937,899,192.09	1,035,060,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	937,899,192.09	1,035,060,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	923,251,074.25	1,025,192,718.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	707,968,830.18	793,742,764.33
210101	Үндсэн цалин	361,762,330.18	417,040,800.00
210102	Нэмэгдэл	217,895,700.00	242,409,107.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,310,000.00	40,164,040.00
210104	Урамшуулал	86,000,800.00	94,128,817.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,229,061.67	99,369,399.46
210201	Тэтгэврийн даатгал	57,928,861.67	66,143,417.33
210202	Тэтгэмжийн даатгал	6,825,000.00	9,282,727.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,460,100.00	6,384,948.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,365,000.00	1,596,137.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,650,100.00	15,962,170.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,438,899.93	46,937,900.00

Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	23,335,517.29	24,799,550.72
210302	Түлш, халаалт	17,713,682.64	17,343,926.32
210303	Цэвэр, бохир ус	3,389,700.00	4,794,422.96
2104	Хангамж, бараа материалын зардал	23,165,841.74	18,637,964.04
210401	Бичиг хэрэг	7,699,810.00	4,350,050.00
210402	Тээвэр, шатахуун	4,279,700.00	3,090,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,102,490.74	7,578,199.04
210404	Ном, хэвлэл	186,900.00	358,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,896,941.00	3,260,405.00
2105	Нормативт зардал	271,000.00	265,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	271,000.00	265,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,214,330.00	5,100,600.00
210604	Урсгал засвар	6,214,330.00	5,100,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,044,248.00	41,243,595.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,237,748.00	35,629,395.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,400.00	127,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,500.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,648,600.00	3,456,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,918,862.73	19,895,495.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,918,862.73	19,895,495.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,648,117.84	9,868,181.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,758,000.00	8,885,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,758,000.00	7,885,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,890,117.84	983,181.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,890,117.84	983,181.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,400,000.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,400,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,400,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,400,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,400,000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,400,000.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	0.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,132,187,517.32		(708,921,176.44)	2,423,266,340.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,132,187,517.32	-	(708,921,176.44)	2,423,266,340.88

Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт	-	1,884,399,809.49		1,884,399,809.49
Тайлант үеийн үр дүн	-		(176,443,830.53)	(176,443,830.53)
2018 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(885,365,006.97)	4,131,222,319.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(885,365,006.97)	4,131,222,319.84
Тайлант үеийн үр дүн	-	-	(131,859,676.61)	(131,859,676.61)
2019 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,017,224,683.58)	3,999,362,643.23

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,003,735,400.00	1,003,202,218.55	533,181.45	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,003,735,400.00	1,003,202,218.55	533,181.45	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	994,850,400.00	994,317,218.55	533,181.45	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	794,189,500.00	793,742,764.13	446,735.87	99.9
Үндсэн цалин	416,231,200.00	417,040,800.00	-809,600.00	100.2
Нэмэгдэл	251,147,500.00	242,409,107.13	8,738,392.87	96.5
Унаа хоолны хөнгөлөлт	40,810,000.00	40,164,040.00	645,960.00	98.4
Урамшуулал	86,000,800.00	94,128,817.00	-8,128,017.00	109.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,374,800.00	99,369,399.46	5,400.54	100.0
Тэтгэврийн даатгал	67,574,900.00	66,143,417.33	1,431,482.67	97.9
Тэтгэмжийн даатгал	7,950,000.00	9,282,727.13	-1,332,727.13	116.8
ҮОМШӨ-ний даатгал	6,359,900.00	6,384,948.00	-25,048.00	100.4
Ажилгүйдлийн даатгал	1,589,900.00	1,596,137.00	-6,237.00	100.4
Эрүүл мэндийн даатгал	15,900,100.00	15,962,170.00	-62,070.00	100.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,937,900.00	46,937,900.00	0.00	100.0
Гэрэл, цахилгаан	18,797,500.00	24,799,550.72	-6,002,050.72	131.9
Түлш, халаалт	24,750,700.00	17,343,926.32	7,406,773.68	70.1
Цэвэр, бохир ус	3,389,700.00	4,794,422.96	-1,404,722.96	141.4
Хангамж, бараа материалын зардал	18,638,000.00	18,637,964.04	35.96	100.0
Бичиг хэрэг	4,208,400.00	4,350,050.00	-141,650.00	103.4
Тээвэр, шатахуун	4,481,000.00	3,090,450.00	1,390,550.00	69.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,954,300.00	7,578,199.04	376,100.96	95.3
Ном, хэвлэл	249,400.00	358,860.00	-109,460.00	143.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,744,900.00	3,260,405.00	-1,515,505.00	186.9
Нормативт зардал	265,000.00	265,000.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	265,000.00	265,000.00	00.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	5,114,600.00	5,100,600.00	14,000.00	99.7
Урсгал засвар	5,114,600.00	5,100,600.00	14,000.00	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,431,200.00	10,368,095.00	63,105.00	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,753,900.00	4,753,895.00	5.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	127,400.00	4,500.00	96.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,800.00	30,000.00	24,800.00	54.7

Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,490,600.00	3,456,800.00	33,800.00	99.0
Бараа үйлчилгээний бусад зардал	19,899,400.00	19,895,495.92	3,904.08	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,899,400.00	19,895,495.92	3,904.08	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,885,000.00	8,885,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	8,885,000.00	8,885,000.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,885,000.00	7,885,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,003,735,400.00	1,003,202,218.75	533,181.25	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,003,735,400.00	1,003,202,218.75	533,181.25	99.9
Улсын төсвөөс санхүүжих	1,003,735,400.00	1,003,202,218.75	533,181.25	99.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
Төсвийн байгууллага	1	1	0	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	53	53	0	100.0
Удирдах ажилтан	1	1	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	40	40	0	100.0
Үйлчлэх ажилтан	12	12	0	100.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		31,325,500.00
УРСГАЛ ЗАРДАЛ		31,325,500.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		30,875,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		30,875,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		30,875,500.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		450,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		450,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		30,875,500.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		30,875,500.00
Улсын төсвөөс санхүүжих		30,875,500.00

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Огноо:	Аудитын нэр:	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код:
2019 он			САГ-2020/149/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шинэ эрин сургууль		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5			9	10
1	Захирлын 2019 оны 2 дугаар сарын 15 өдрийн А/05 тушаалаар багш, ажилчдын 2018 оны 9-12 сар, 2019 оны 1 дүгээр сарын ажлын үр дүнгээр 2019 оны 2-6 сарын үр чадварын нэмэгдлийг, 2019 оны 6 дугаар сарын 14 өдрийн А/13 тушаалаар багш нарын 2-6 сарын ажлын үр дүнгээр 2019 оны 9-12 сарын үр чадварын нэмэгдлийг олгоходоо 3,225.9 мянган төгрөг илүү олгожээ.	3,225.9	төлбөрийн акт	2020.02.20		Захирал, Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б. Болор-эрдэнэ
2	Захирлын 2019 оны 2 дугаар сарын 15 өдрийн А/06 тушаалаар багш, ажилчдын 2018 оны 9-12 сар, 2019 оны 1 дүгээр сарын ажлын үр дүнгээр 2019 оны 1.2 дугаар улирлын урамшуулал, 2019 оны 6 дугаар сарын 14 өдрийн А/14 тушаалаар багш нарын 2-6 сарын ажлын үр дүнгээр 3.4 улирлын урамшуулал олгоходоо 1,438.5 мянган төгрөгийн урамшуулал илүү олгожээ.	1,438.5	төлбөрийн акт	2020.02.20		Захирал, Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б. Болор-эрдэнэ
3	. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 447 дугаар тогтоолоор 50,654.2 мянга, А-1/3719 тоот албан бичгээр 231,597.5 мянга, нийт 282,251.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах зөвшөөрлийн дагуу машин тоног төхөөрөмж 244,301.5 мянга, тавилга, эд хогшил 21,580.5 мянга, ном 9,295.7 мянга, нийт 275,177.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж 7.074.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдаагүй үлдсэн байна.	7,074.0	Залруулга хийсэн	2020.02.20		Захирал, Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б.Дэлгэрцэцэг
4	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх болон 2019 оны 01 дүгээр сарын 01-нээрх үлдэгдлийг 1,585,496.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1,585,496.6	Залруулга хийсэн	2020.02.20		Захирал, Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б.Дэлгэрцэцэг
5	Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулалгүйгээр 30,875.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.	30,875.5	Зөвлөмж өгсөн	2020.02.20		Захирал, Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б. Болор-эрдэнэ
6	Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс санхүүгийн үр дүнгийн тайлан 302.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Цалингаас НДШ 144.6, ХХОАТ 79.1 сая төгрөгөөр тус тус илүү суутгасан байна.	526.0	Зөвлөмж өгсөн	2020.02.20		Захирал, Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б. Болор-эрдэнэ
7	Тус сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Үндэсний аудитын газарт ирүүлэхдээ тайлбар тодруулга дутуу ирүүлсэн байна.		Зөвлөмж өгсөн	2020.02.20		Захирал, Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б.Дэлгэрцэцэг
8	Ерөнхий боловсролын 640 хүүхдийн сургуулийн/эскиз/ 2008 оны зургаар 1369.2 кв.м /45.64x30/ талбай бүхий 3 давхар сургуулийн барилга, 125 кв.м /25x 5/ талбай бүхий автомашины гарааш Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 20 дугаар сургуулийн хашаанд баригдсан байна. Сургуулийн барилга, автомашины гараашын талаарх мэдээлэл, холбогдох бичиг баримт материал хангалтгүй байна.		Зөвлөмж өгсөн	2020.02.20		Захирал, Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б.Дэлгэрцэцэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 02

№ 01/31

Улаанбаатар хот

САГ- 0020/149/СТА- тцз

Илүү олгосон нэмэгдэл цалинг
төлүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Шинэ эрин сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Захирлын тушаалд заасан хувь хэмжээг өөрчлөн урамшуулал цалинг 46 ажилтанд 3,225,864.00 төгрөг, ур чадварын нэмэгдлийг өөрчлөн сүүлийн 12 сарын турш 1-28 ажилтанд 1,438,555.00 төгрөг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон нэмэгдэл цалин 4,764,419.00 /Дөрвөн сая долоон зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун арван есөн/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх.
2. Биелэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шинэ эрин сургуулийн захирал Б.Амартүвшин, нягтлан бодогч Б.Дэлгэрцэцэг нарт даалгав.

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР
Д.ЦЭРЭНДОРЖ

АКТЫГ:

ЗӨВШӨӨРСӨН:

ШИНЭ ЭРИН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.АМАРТҮВШИН
НЯГТЛАН БОДОГЧ
Б.ДЭЛГЭРЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

